



МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛЫН
САЙДЫН ТУШААЛ

2025 оны 02 сарын 14 өдөр

Дугаар А/69

Улаанбаатар хот

Журамд нэмэлт, өөрчлөлт
оруулах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Боловсролын ерөнхий хуулийн 26 дугаар зүйлийн 26.1.22 дахь заалт, Дээд боловсролын тухай хуулийн 18.3 дахь заалтыг тус тус үндэслэн, Монгол Улсын Ерөнхий сайдын 2024 оны 09 дүгээр сарын 18-ны өдрийн 01 дугаартай албан даалгаврын 16.4 дэх заалтыг хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ НЬ:

1. Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2024 оны "Журам батлах тухай" А/66 дугаар тушаалын хавсралтаар баталсан "Элсэлтийн шалгалт зохион байгуулах журам"-д доор дурдсан агуулга бүхий 2.2.1.5, 2.9, 2.10, 2.11, 5.1.1, 6.3.1.3 дахь заалтыг тус тус нэмсүгэй.

1/. 2.2.1.5.Ерөнхий боловсролын сургуулийн 10, 11 дүгээр ангийн суралцагч Суралцах чадварын шалгалтад өөрийн хүсэлтээр хамрагдаж болно. Энэ тохиолдолд шалгалтын зардлыг суралцагчийн эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч хариуцна.

2/. 2.9.Ерөнхий боловсролын сургуулийн 10, 11 дүгээр ангийн суралцагч Монгол хэл, бичгийн шалгалтад өөрийн хүсэлтээр хамрагдаж болно. Энэ тохиолдолд шалгалтын зардлыг суралцагчийн эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч хариуцна.

3/. 2.10.Ерөнхий боловсролын сургуулийн 10, 11 дүгээр ангийн суралцагч Монгол хэл, бичгийн шалгалт өгч, тухайн жилд зарласан босго оноог хангасан тохиолдолд дахин шалгалт өгөхгүй.

4/. 2.11.Ур чадварын шалгалтыг эрх бүхий этгээдийн баталсан журмын дагуу тухайн дээд боловсролын сургалтын байгууллага зохион байгуулна.

5/. 5.1.1.Энэхүү журмын 5.1 дэх заалт нь монгол хэл, бичгийн шалгалт болон суралцах чадварын шалгалтад өөрийн хүсэлтээр хамрагдах ерөнхий боловсролын сургуулийн 10, 11 дүгээр ангийн суралцагчид хамаарахгүй.

6/. 6.3.1.3. АР хөтөлбөрийн олон улсын шалгалт

№	AP	Элсэлтийн шалгалт 2025 оныг дуустал мөрдөх	Элсэлтийн шалгалт 2026 оноос мөрдөж эхлэх
1	AP English Language and composition, AP English Literature and composition	Англи хэл	Англи хэл-I
2	AP Calculus AB, BC, AP statistics	Математик	Математик-II
3	AP Physics 1, 2, C	Физик	Физикт суурилсан байгалийн ухаан
4	AP Chemistry	Хими	Химид суурилсан байгалийн ухаан
5	AP Biology	Биологи	Биологид суурилсан байгалийн ухаан
6	AP Human Geography	Газар зүй	Нийгмийн ухаан-III

2. Мөн журмын 6.7.8 дахь заалтад доор дурдсан хүснэгт нэмсүгэй.

Элсэлтийн шалгалт	A	A-	B
AP	5	4	3

3. Мөн журмын 2.1 дэх заалтын тайлбар хэсгийн "2.1" гэсний дараа 2.5, 2.6, 2.7" гэж, мөн журмын 7.1 дэх заалтын "шалгалтын зохион байгуулалт" гэсний дараа "бүртгэл" гэж тус тус нэмсүгэй.

4. Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2024 оны "Журам батлах тухай" А/66 дугаар тушаалын хавсралтаар баталсан "Элсэлтийн шалгалт зохион байгуулах журам"-ын 2.2.2, 2.2.2.1, 3.1, 6.4 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай.

1/. 2.2.2. Судлагдахууны 2 түвшинт шалгалт" нь англи хэл-I, англи хэлний олон улсын шалгалт, математик-I, II, монгол хэл-I, II, орос хэл-II, Физикт суурилсан байгалийн ухаан, химид суурилсан байгалийн ухаан, биологид суурилсан байгалийн ухаан, нийгмийн ухаан- I, II, III гэсэн түвшинтэй, тестийн хэлбэртэй байна.

2/. 2.2.2.1 "Физикт суурилсан байгалийн ухаан" шалгалтыг ерөнхий боловсролын сургуулийн физикийн судлагдахууныг сонгон судлах, хими, биологийн судлагдахууныг заавал судлах, "Химид суурилсан байгалийн ухаан" шалгалтыг ерөнхий боловсролын сургуулийн химийн судлагдахууныг сонгон судлах, физик, биологийн судлагдахууныг заавал судлах, "Биологид суурилсан байгалийн ухаан" шалгалтыг ерөнхий боловсролын сургуулийн биологийн судлагдахууныг сонгон судлах, физик, химийн судлагдахууныг заавал судлах хөтөлбөрийн агуулгын хүрээнд авна."

3/3.1.Элсэлтийн шалгалт болон монгол хэл, бичиг (суралцах чадварын шалгалт)-ийн шалгалтыг жилд хоёр удаа зохион байгуулна.

4/ 6.4.Монгол Улсад ерөнхий боловсрол эзэмшсэн, эсхүл дүйцүүлсэн баримт бичигтэй, төгсөх ангид суралцаж байгаа, олон улсад нийтлэг хүлээн зөвшөөрдөг шалгалтын үнэлгээтэй Монгол улсын иргэн, оюутан, суралцагчид элсэлтийн шалгалтын үнэлгээтэй дүйцүүлэхээр хүсэлтээ гарган хамрагдах боломжтой.

5. Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2024 оны “Журам батлах тухай” А/66 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Элсэлтийн шалгалт зохион байгуулах журам”-ын 2.1 дэх заалтын тайлбар хэсгийн болон 6.3 дахь заалтын хүснэгт дэх “2025 оныг дуустал” гэснийг “2028 оны 7 сар хүртэл” гэж өөрчилсүгэй.

6. Мөн журмын 2.2 дахь заалтын тайлбар хэсгийн болон 6.3 дахь заалтын хүснэгт дэх “2026 оноос” гэсэн тохиолдол бүрийг “2028 оны 12 сараас” гэж тус тус өөрчилсүгэй.

7. Мөн журмын 6.3.1.1, 6.3.1.2 дахь заалтын “байгалийн ухаан-I” гэснийг “Физикт суурилсан байгалийн ухаан” гэж, “байгалийн ухаан II” гэснийг “химид суурилсан байгалийн ухаан” гэж, “байгалийн ухаан III” гэснийг “биологид суурилсан байгалийн ухаан” гэж тус тус өөрчилсүгэй.

8. Мөн журмын 6.7.7-д заасан SAT-ийн үнэлгээг элсэлтийн шалгалтын үнэлгээтэй дүйцүүлэхэд гэсэн хүснэгтийг доор дурдсанаар өөрчилсүгэй.

Элсэлтийн шалгалт	A	A-	B	B-	C	C-
SAT	751-800	701-750	651-700	601-650	551-600	501-550

9. Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2024 оны “Журам батлах тухай” А/66 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Элсэлтийн шалгалт зохион байгуулах журам”-ын заасан “элсэлтийн шалгалт” гэсэн тохиолдол бүрийг элсэлтийн шалгалт болон монгол хэл, бичиг (цаашид суралцах чадварын шалгалт)-ийн шалгалт гэж өөрчилсүгэй.

10. Энэхүү тушаалыг баталсантай холбогдуулан ерөнхий боловсролын сургуулийн багш, ахлах ангийн суралцагч, эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч нарт болон олон нийтэд таниулан сурталчлахыг Боловсролын ерөнхий газар /Т.Ням-Очир/, аймаг, нийслэлийн боловсролын газрын дарга нарт тус тус үүрэг болгосугай.

САЙД

П.НАРАНБАЯР

